

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийг үүсгэн байгуулах, түүний зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль тогтоомж

2.1. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3. Биржийн үйл ажиллагаатай холбогдсон энэ хуулиар нарийвчлан зохицуулаагүй харилцааг Компанийн тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтаар зохицуулна.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "хөдөө, аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж" /цаашид "бирж" гэх/ гэж 3.1.2-т заасан бараа, түүхий эдийн арилжааг тогтсон журмын дагуу зориулалтын байранд мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан төрөл, хэлбэрээр зохицуулан явуулдаг төрийн өмчит компанийг;

3.1.2. "хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд" /цаашид "бараа, түүхий эд" гэх/ гэж гарал үүсэл болон чанарын гэрчилгээтэй, биржээр арилжихаар зохих журмын дагуу бүртгэгдэн тодорхой хэмжээгээр багцалсан хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг;

3.1.3. "биржийн арилжаанд оролцогч" гэж биржид бараа, түүхий эд арилжих зорилгоор бүртгүүлсэн, арилжаанд оролцох зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээд, арилжааны зуучлагч /брокер/-ийг;

3.1.4. "арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа" гэж хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэгчээс өөрийн хөрөнгөөр худалдан авч холбогдох стандартад нийцүүлэн анхан шатны боловсруулалт хийж биржээр зуучлан арилжих ажиллагааг;

3.1.5. "биржийн арилжаа" гэж биржийн арилжаанд оролцогчдын хооронд хийгдэх бараа, түүхий эдийг арилжих үйл ажиллагааг;

3.1.6. ”нэг загварын гэрээгээр ирээдүйд нийлүүлэх бараа, түүхий эдийн арилжаа” гэж чанар, стандартын шаардлага хангасан бараа, түүхий эдийг зах зээлийн ирээдүйн үнээр арилжих хэлцлийг;

3.1.7. “хугацаа хойшлуулах, сунгах нөхцөл бүхий ирээдүйд нийлүүлэх бараа, түүхий эдийн арилжаа” гэж чанар, стандартын шаардлага хангасан бараа, түүхий эдийг урьдчилан тохиролцсон үнээр ирээдүйд арилжих хэлцлийг;

3.1.8. “суудлын эрх” гэж биржийн арилжаанд тогтмол оролцох зөвшөөрлийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Бирж, түүний үйл ажиллагаа

4 дүгээр зүйл. Бирж

4.1. Монгол Улсын хэмжээнд зөвхөн нэг бирж үйл ажиллагаа явуулна.

4.2 Бирж үйл ажиллагаандаа бие даасан, олон нийтэд ил тод байх, байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, хувь хүн, улс төрийн намын эрх ашигт хөтлөгдөхгүй байх үндсэн зарчмыг баримтална.

4.3. Бирж нь мэдээллийн сан, арилжааны сүлжээ, төлбөр тооцооны төв бүхий зориулалтын байртай байна.

4.4. Биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалтыг хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

4.5. Хөдөө аж ахуй, худалдааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас биржээр арилжихаар баталсан нэр бүхий бараа, түүхий эдийг экспортод гаргахдаа биржид бүртгүүлэх буюу биржээр дамжуулан арилжина.

4.6. Биржээс гадуурх аливаа арилжаанд биржийн нэр ашиглахыг хориглоно.

4.7. Биржтэй холбогдсон маргаантай асуудлыг арбитраар шийдвэрлүүлж болно.

4.8 Биржийн дүрмийг Компанийн тухай хуульд нийцүүлэн Засгийн газар батална.

5 дугаар зүйл. Биржийн чиг үүрэг

5.1. Бирж нь дараахь нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.1.1. биржийн арилжааг зохион байгуулах ;

5.1.2. биржийн оролцогчийг бүртгэх

5.1.3. биржийн гишүүн оролцогчид суудлын эрх олгох, хэрэв биржийн гишүүн оролцогч нь хуулийн этгээд бол түүнийг төлөөлөн биржийн арилжаанд оролцох ажилтныг бүртгэх

5.1.4. гишүүн биш оролцогчид биржийн арилжаанд оролцох зөвшөөрөл олгох

5.1.5. биржээр арилжсан бараа, түүхий эдэд энэ хуулийн 13.1.3-т заасан дүгнэлтийг үндэслэн чанарын гэрчилгээг олгох;

5.1.6. энэ хуулийн 4.5-т заасан бараа, түүхий эдэд гарал үүслийн гэрчилгээ олгох;

5.1.7. биржээр арилжих болон арилжигдсан бараа, түүхий эдийг бүртгэх, арилжсан барааны төлбөр тооцоог хийх;

5.1.8. Биржийн арилжаанд оролцогчийг сургах, мэргэшүүлэх, аттестатчлах;

5.1.9. биржийн арилжаанд оролцогчийг шаардлагатай мэдээллээр хангах.

6 дугаар зүйл Биржийн арилжааны төрөл, хэлбэр

6.1. Биржийн арилжаа нь цахим хэлбэрийг ашиглан дуудлага худалдааны хэлбэрээр явагдах бөгөөд дараахь төрөлтэй байна:

6.1.1. биржид бүртгэгдсэн бэлэн байгаа бараа, түүхий эдийн арилжаа;

6.1.2. ирээдүйд нийлүүлэх бараа, түүхий эдийн арилжаа;

6.1.3. энэ зүйлийн 6.1.2-т заасан арилжааг дараах байдлаар ангилна:

6.1.3.1. нэг загварын гэрээгээр ирээдүйд нийлүүлэх бараа, түүхий эдийн арилжаа;

6.1.3.2 хугацааг хойшлуулах, сунгах нөхцөл бүхий ирээдүйд нийлүүлэх бараа, түүхий эдийн арилжаа.

7 дугаар зүйл.Биржийн арилжааны журам

7.1. Биржийн арилжааны журмыг зөвлөл батална.

7.2. Биржийн арилжааны журмаар арилжааны өмнөх, арилжааны үеийн, арилжааны дараа явагдах дараахь харилцааг зохицуулна:

7.2.1. бараа, түүхий эдийг бэлтгэх, хадгалах, тээвэрлэх;

7.2.2. бараа, түүхий эдийн баглаа боодлын шаардлага;

7.2.3. бараа, түүхий эдийг бүртгэх;

7.2.4. агуулахад бараа, түүхий эдийг бүртгэн хүлээн авах;

7.2.5. биржийн хэлцэл;

7.2.6. бараа, түүхий эдийн үнэ ханшийг судлах, хяналт тавих;

7.2.7. биржийн арилжаа явуулах үйл ажиллагаа;

7.2.8. биржийн арилжааны төлбөр, тооцоо хийх;

7.2.9. мэдээллийн сан, арилжааны сүлжээ ажиллуулах;

7.2.10. биржийн арилжаанд оролцогчийн үйл ажиллагааг зохицуулах;

7.2.11. биржээс биржийн арилжаанд оролцогчид үзүүлэх үйлчилгээ;

7.2.12. бусад.

8 дугаар зүйл. Биржийн зөвлөл

8.1. Бирж зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх)-тэй байна.Зөвлөл нь биржийн эрх барих дээд байгууллага мөн.

8.2. Зөвлөл нь энэ хуульд өөрөөр заагаагүй бол Компанийн тухай хуулийн 63.1-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

8.3. Биржийн зөвлөл нь 9 гишүүнтэй байх бөгөөд Зөвлөлийн гишүүдэд Санхүүгийн зохицуулах хороо, Төрийн өмчийн хороо, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тус бүр 1 хүний, Засгийн газар 6 хүний нэрийг тус тус дэвшүүлж, тэдгээрийг Засгийн газар томилно.

8.4. Зөвлөлийн даргыг гишүүдийн дотроос Засгийн газар томилно.

8.5. Зөвлөлийн дарга, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 6 жил байна.

8.6. Зөвлөлийн дарга, гишүүн эдийн засаг, санхүү, худалдаа, хөдөө аж ахуй, эрх зүйн аль нэг чиглэлээр мэргэжил эзэмшсэн, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, ял шийтгүүлж байгаагүй иргэн байна.

8.7. Зөвлөлийн дарга, гишүүнд дараахь этгээдийг нэр дэвшүүлэхгүй:

8.7.1. төрийн улс төрийн албан хаагч

8.7.2. төрийн тусгай албан хаагч

8.8. Зөвлөлийн дарга, гишүүдэд дараахь шаардлага тавина:

8.8.1. татварын болон бусад хугацаа хэтэрсэн аливаа өргүй;

8.9. Зөвлөлийн ээлжит хуралдааныг улиралд нэгээс доошгүй удаа хийнэ.

8.10. Биржийн гүйцэтгэх захиралыг Зөвлөл томилж, чөлөөлнө.

9 дүгээр зүйл. Биржийн үйл ажиллагаатай холбоотой аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

9.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1. биржийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвт тусган батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

9.1.2. биржийн үйл ажиллагаатай холбогдсон мэдээлэл, судалгааг тогтмол явуулж, үр дүнг холбогдох төрийн байгууллагад мэдээлэх;

9.1.3. тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны зуучлагч /брокер/-тай энэ хуулийн 13.3.1-т заасан гэрээг байгуулж хэрэгжилтэд нь хяналт тавих;

9.1.4. биржээр арилжих бараа, түүхий эдийг бэлтгэх болон бэлтгэгдсэн бараа, түүхий эдэд гарал үүсэл, чанарын дүгнэлт өгөх, тоо хэмжээг баталгаажуулан гэрчлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих;

9.1.5. тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй арилжааны зуучлагч /брокер/, иргэн, хуулийн этгээдээс биржийн арилжаатай холбогдон гарсан санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх

9.2. орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны зуучлагч /брокер/ бараа, түүхий эдийг тухайн орон нутгаасаа шууд экспортлох бол биржид цахим хэлбэрээр бүртгүүлснийг үндэслэн гарал үүслийн гэрчилгээг **Засаг дарга** олгоно.

10 дугаар зүйл. Биржийн санхүүжилт

10.1. Биржийн санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

10.1.1. улсын болон орон нутгийн төсөв;

10.1.2. бусад.

11 дүгээр зүйл. Биржийн ажилтанд хориглох зүйл

11.1. Биржийн ажилтанд дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

11.1.1. биржийн арилжаанд оролцох;

11.1.2. арилжааны зуучлагч /брокер/-ийн компани байгуулах;

11.1.3. арилжаанд оролцогчийн арилжааны нууцыг агуулсан мэдээ, мэдээллийг хувийн сонирхлоор ашиглах, бусдад задруулах;

11.1.4. арилжааны зуучлагч /брокер/-тай үгсэн хуйвалдаж арилжааг шударга бусаар явуулах;

11.1.5. бараа, түүхий эдийн үнэ ханшинд нөлөөлж болох мэдээллийг орхигдуулах, нуун дарагдуулах, зохих журмын дагуу мэдээлэл өгөхөөс татгалзах;

11.1.6. ажил, үүргээ гүйцэтгэсний төлөө бусад этгээдээс урамшуулал, мөнгөн шагнал, шан харамж авах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Биржийн арилжаанд оролцогч

12 дугаар зүйл. Биржийн арилжаанд оролцогч

12.1. Биржийн арилжаанд оролцогчийг биржийн гишүүн оролцогч ба биржийн гишүүн бус оролцогч гэж ангилна.

12.2. Арилжааны зуучлагч /брокер/ нь биржийн гишүүн оролцогч байна.

12.3. Иргэн, хуулийн этгээд нь биржийн гишүүн бус оролцогч байх бөгөөд тэдгээрийн арилжаанд оролцох үйл ажиллагааг Биржийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

12.4. Биржийн гишүүн оролцогч нь биржийн арилжаанд оролцох суудлын эрх, гишүүн бус оролцогч нь биржийн арилжаанд оролцох зөвшөөрлийг биржээс тус тус авсан байна.

12.5. Биржийн арилжаанд дараахь этгээдийг оролцохыг хориглоно:

12.5.1. биржийн ажилтан;

12.5.2. даатгал, тусламжийн сан, тэдгээрийн ажилтан.

12.5.3. хууль тогтоомжоор аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон бусад этгээд.

13 дугаар зүйл. Биржийн арилжаанд оролцогчийн эрх, үүрэг

13.1. Биржийн арилжаанд оролцогч нь дараахь нийтлэг эрх, үүрэгтэй байна:

13.1.1. биржийн арилжааны мэдээллийг ашиглах;

13.1.2. биржийн арилжааг үнэн зөв, шударгаар явуулах;

13.1.3. бараа, түүхий эдийг зохих стандартын /бэлтгэх, хадгалах, тээвэрлэх, баглаа боодлын/ дагуу бэлтгэн холбогдох мэргэжлийн байгууллагаар стандарт-чанарын шаардлага хангасан тухай дүгнэлт гаргуулсан байх;

13.1.4. бараа, түүхий эдийн чанар, тоо хэмжээг биржид үнэн зөв мэдээлэх, бүртгүүлэх;

13.1.5. энэ зүйлийн 13.1.4-т заасныг зөрчсөнөөс худалдан авагчид учирсан хохирлыг хариуцан барагдуулах;

13.1.6. биржийн дүрэмд заасан бусад эрх, үүрэг.

13.2. Биржийн гишүүн оролцогч нь дараахь давуу эрх эдэлнэ:

13.2.1. арилжааны мэдээллийг үнэ төлбөргүй ашиглах;

13.2.2. бирж дээр үйл ажиллагаа явуулах бусад дэмжлэг авах;

13.3. Биржийн гишүүн оролцогч нь энэ хуулийн 13.1-д заасан нийтлэг үүргээс гадна дараахь үүрэгтэй байна:

13.3.1. аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргатай бараа, түүхий эдийг зохих стандартын дагуу бэлтгэх, хадгалах, тээвэрлэхтэй холбогдсон гэрээ байгуулах;

13.3.2. бараа, түүхий эдийг хүлээн авах, хадгалах, бэлтгэх зориулалтын агуулахтай байх;

13.3.3. бараа, түүхий эдийг тухайн орон нутгаасаа шууд экспортлох бол биржид цахим хэлбэрээр бүртгүүлж, гарал үүслийн гэрчилгээг сум, дүүргийн Засаг даргаас авах;

13.3.4. биржийн арилжааг өөрийн хөрөнгөөр эрхлэн явуулах;

13.3.5. арилжааны сүлжээнд холбогдсон байх.

14 дүгээр зүйл. Биржийн арилжаанд оролцогчид хориглох зүйл

14.1. Биржийн арилжаанд оролцогчид дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

14.1.1. биржийн арилжаанд оролцогч болон түүний бараа, түүхий эдийн нэр хүндийг гутаах, эсхүл өрсөлдөгчөө алдагдалд оруулж болохуйц худал, зөрүүтэй буюу гуйвуулсан мэдээ тараах;

14.1.2. харилцан тохиролцох замаар биржээр арилжих бараа, түүхий эдийн үнийн түвшинд хязгаар тогтоох;

14.1.3. өөрийн болон биржийн арилжаанд оролцогч бусад этгээдийн бараа, түүхий эдийг бэлтгэсэн буюу үйлдвэрлэсэн газар, түүний байршил, түүнчлэн бараа, түүхий эдийг үйлдвэрлэсэн арга, хэрэглээний шинж чанарын гол үзүүлэлт, хэрэглэх аргын талаар худал, зөрүүтэй мэдээлэх, эсхүл үнэн байдлыг гуйвуулах зэргээр бусдыг төөрөгдүүлэх, хуурч мэхлэх;

14.1.4. хууль тогтоомжоор хориглосон бусад үйл ажиллагаа.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Биржийн үйл ажиллагаанд тавих хяналт

15 дугаар зүйл. Биржийн хяналтын хороо

15.1. Биржийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавих чиг үүргийг хяналтын хороо хэрэгжүүлнэ.

15.2. Хяналтын хороо нь 9 гишүүнтэй байх бөгөөд хяналтын хорооны гишүүдэд Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус бүр 1 хүний Засгийн газар 5 хүний нэрийг тус тус дэвшүүлж, тэдгээрийг Зөвлөл томилж чөлөөлнө.

15.3. Хяналтын хорооны гишүүдийн 5-аас доошгүй нь хөдөө аж ахуй, худалдааны салбарын мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын төлөөлөл байна.

15.4. Хяналтын хорооны даргыг гишүүдийн дотроос сонгож Зөвлөл томилж, чөлөөлнө.

15.5. Хяналтын хороо нь үйл ажиллагаагаа Зөвлөлд тайлагнана.

15.6. Хяналтын хорооны эрх, үүрэг, үйл ажиллагааны журмыг биржийн дүрмээр зохицуулна.

16 дугаар зүйл. Аудит

16.1. Биржийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд Үндэсний аудитын газар жил бүр аудит хийж дүгнэлт гаргана.

16.2. Үндэсний аудитын газар нь энэ хуулийн 16.1-д заасан дүгнэлтээ Засгийн газарт танилцуулна.

17 дугаар зүйл. Биржийн тайланг нийтэд мэдээлэх

17.1. Биржийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

18 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

18.1 Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр бол эрх бүхий улсын байцаагч зөрчлийн шинж байдлыг харгалзан дараахь хариуцлага хүлээлгэнэ:

18.1.1. энэ хуулийн 4.5-д заасныг зөрчин биржийн нэр ашиглан бараа, түүхий эдийг арилжсан иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгож, хууль бусаар олсон орлогыг хураах;

18.1.2. энэ хуулийн 14.1.1-14.1.4-д заасныг зөрчсөн биржийн гишүүн бус оролцогчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, гишүүн оролцогчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй

тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгож, олсон орлогыг хураах, энэ зөрчлийг давтан гаргавал бирж дээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг хүчингүй болгох;

18.1.3. энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасныг зөрчсөн биржийн ажилтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

19 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

19.1.Энэ хуулийг 20.. оны .. дугаар сарын ..-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг